



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А1554

Сүхбаатар сум

Дотоод аудитын хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол "Дүрэм батлах тухай" 4.12, 4.13, Сангийн Сайдын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 29 дүгээр тушаалаар баталсан "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн 1.3, 2.1, 2.2, 5.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дотоод аудитын албаны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, түүний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан дотоод аудитын тайланг хэлэлцэн шийдвэрлэх, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө дэмжлэг үзүүлэх зорилготой аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:

Дарга: (Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч)

Гишүүд: (Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга)
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
(Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)
(Хууль эрх, зүйн хэлтсийн дарга)
(Төрийн бус байгууллагын төлөөлөл)
(Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: (Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч,
дотоод аудитор)

2. "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Сангийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 29 дүгээр тушаалыг мөрдөж ажиллахыг "Дотоод аудитын хороо"-нд даалгасугай.



Н.ЛХАГВАДОРЖ